



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 23

Номгон

Баянцагаан сумын сум дундын хүн эмнэлгийг
Анагаах ухааны доктор, профессор Ө.Жүгдэрийн
нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянцагаан сумын сум дундын хүн эмнэлгийг Анагаах ухааны доктор, профессор Ө.Жүгдэрийн нэрэмжит болгосугай.

2. Баянцагаан сумын сум дундын хүн эмнэлгийг Анагаах ухааны доктор, профессор Ө.Жүгдэрийн нэрэмжит болгосонтой холбогдуулан ажил үйлсийг хойч үеийнхэнд таниулж, гавьяат үйлсийг нь алдаршуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Л.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР